



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/22

Улиастай


Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дартсын спортын Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдын зардалд зориулж 1,978,000 (нэг сая есөн зуун далан найман мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Мягмарсүрэн)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Чадраабал)-т даалгасугай.

ДАРГА  Т. ЧАДРААБАЯР



Захирамж-2023

8139010099